



## НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 4/07

Улаанбаатар хот

### Ажлын төлөвлөгөө батлах тухай

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас баталсан “Хотын Соёл” аяны удирдамжийг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын Төрөөс соёлын талаар баримтлах бодлого, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Бүх шатны боловсрол, соёлын байгууллагууд болон олон нийтийн сүлжээг ашиглан соёлын боловсрол олгох “Хотын соёл” олон нийтийн аян өрнүүлэх”-ээр тусгагдсан заалтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Ажлын төлөвлөгөөний явцад хяналт тавьж, удирдлагад мэдээлж, тайлагнаж ажиллахыг албаны дарга /Д.Баянзул/, хүний нөөцийн ажилтан /П.Сэрсмаа/ нарт даалгасугай.

ЗАХИРАЛ



*Б.Байгалмаа*

Б.БАЙГАЛМАА

Нийслэлийн Соёлын Төв  
Өргөөний захирлын 2020 оны 15  
сарын 15 өдрийн 1104 тоот  
тушаалын нэгдүгээр хавсралт



“ХОТЫН СОЁЛ” УДИРДАМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

| Д/д | Хэрэгжүүлэх арга хэмжээ                                                                                                                                                                                                                    | Хугацаа         | Хариуцагч |
|-----|--------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-----------------|-----------|
| 1   | “Хотын Соёл” олон нийтийн аяныг дэмжин оролцож Соёлын Төв Өргөөний “Их танхим”-д болж байгаа арга хэмжээний үед үзэгчдийн үзвэр үзэх соёлыг дээшлүүлэхэд зориулсан аудио бичлэгийг бэлтгэн арга хэмжээ эхлэхээс өмнө тогтмол явуулж хэвших | 6-р сард        | Д.Баянзул |
| 2   | Байгууллагын албан ёсны “Соёлын Төв Өргөө” Facebook хуудас болон www.stu.ub.gov.mn вэбсайтаар дамжуулан үзэгчдийн үзвэр үзэх соёлыг дээшлүүлэхэд зориулсан мэдээ мэдээллийг хүргэж ажиллах                                                 | Долоо хоног бүр | Д.Баянзул |
| 3   | Байгууллагын албан ёсны “Соёлын Төв Өргөө” Facebook хуудасны ковер зургийг “Хотын Соёл” олон нийтийн аяны албан ёсны зургаар 2020 оны 03 дугаар сарын 25-наас 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл солих                           | 3 сарын 25-нд   | Д.Баянзул |
| 4   | Нийслэлийн Соёл Урлагийн газраас гаргаж буй цуврал нэвтрүүлэг, видео, контентийг “Соёлын Төв Өргөө” Facebook хуудсаар дамжуулан олон нийтэд давалагаалж сурталчлах                                                                         | Тухай бүр       | Д.Баянзул |